

ШУТИС-ийн оюутны сайн дурын клубүүдийн тайлан хэлэлцэх хурал боллоо.

ШУТИС-ийн оюутны сайн дурын клубүүдийн тайлан хэлэлцэх хурал 2015 оны 12 сарын 30 нд 12:00-14:00 цагт ШУТТН-ын сангийн 604 тоот танхимд болов.

ШУТИС-ийн оюутнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, авъяас сонирхолд нь тулгуурлан хувь хүн , баг хамт олноор нь хөгжүүлэн төлөвшүүлэх зорилго тавьж клубүүдийг дэмжин ажиллаж байгаа билээ. Клубүүдийг дэмжих зорилгоор клубүүдэд “Оюутны хөгжил” танхим тохижуулан хуваарийн дагуу үйл ажиллагааг явуулах боломж олгон ажиллаж байна.

Тус ажлын хүрээнд ШУТИС-ийн оюутнууд хүсэл сонирголоороо нэгдэн клуб байгуулж хичээллэж, үйл ажиллагаа явуулж хамтран ажиллаж буй үр дүн жилээс жилд нэмэгдэн клубүүдийн үйл ажиллагааны цар хүрээ, оюутнуудыг хамрах байдал зэрэг нэмэгдэж байгаа нь тайлан хэлэлцэх хурлаар тодорхой харагдлаа.

Тайлан хэлэлцэх хуралд клубийн ахлагч нар гишүүдийн хамт мөн зөвлөх багш нар нь хүрэлцэн ирсэн байлаа.

Тайлангийн хуралд:

“Хөгжлийн жигүүр” клуб : Тус клуб нь 11 гишүүнтэй зөвлөх багшаар ХШУС-ийн багш Д.Бурмаа ажиллаж байна. Тус клуб нь элсэн суралцагчидад дэмжлэг тусалцаа үзүүлэх ШУТИС-ийн “Багш, оюутны долоо хоног” хөтөбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажилд идэвх чармайлттай ажилладаг. ОХҮА-наас ТАЛАРХАЛ хүлээсэн клуб юм.

“AIESEC-MUST” клуб ахлагч ШУТИС-ийн оюутны гадаад харилцаа, хэлний мэдлэгийг дэмжихэд чиглэсэн олон улсын чанартай үйл ажиллагаанд оюутныг татан оролцуулах боломж бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн олон үйл ажиллагааг зохион байгуулдаг клуб. Энэ өвлийн амралтаар 4 оюутныг гадаадын солилцооны хөтөлбөрт хамруулсан байна.

“My club” клуб ШУТИС-ийн оюутны Эко боловсролыг дэмжих зорилготой клуб, Клубийн зөвлөх багшаар БУХС-ийн ахлах багш Д.Сэрдарам ажиллаж байна. Нийт давхардсан тоогоор улсын хэмжээний 10000 гаруй гишүүнтэй . 2015 оны байдлаар 2415 хүнийг хамарсан 20 гаруй сайн үйлсийн ажил хийсэн байна. Мөн Мицибуши корпорацийн нэрэмжит төсөлд шалгаран жилийн ажлын зардлаа даалгасан байна.

“Багшийн туслах оюутан” клуб нийт 15 зөвлөх багш, 15 оюутан багшийн бүрэлдэхүүнтэйгээр 8 төрлийн хичээлийг 2269 оюутанд зорилтот хичээлийг 931 оюутанд хүргэсэн байна. Клубийн зөвлөх багшаар ХШУС-ийн ахлах багш А.Эрдэнэсүвд ажиллаж байна.

“Соёл” клуб, “Мэргэн шагайн харваа” клуб, “Empowerment” клуб, “Хос уянга” клуб, “Хятад хэл”-ний клуб, “Ойхон” клубүүд тайлангаа хэлэлцүүлээ.

Тайлангийн хурлыг ОХҮА-ны хамт олон, ХШУС-ийн ахлах багш А.Эрдэнэсүвд нар сонсож дүгнэлээ.

Тайлангийн хуралд ирсэн зөвлөх багш нар клубүүдийн үйл ажиллагааг сонсож бахархан оюутнууд энэ их үйл ажиллагааг санаачлан хийж байгааг багш бид нар ч мэддэггүй юм байна. Зарим клубд нь элсэн орж суралцах зүйл их байгааг хэлж байлаа.

Оюутны хөгжил, үйлчилгээний алба